



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 2/61

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний гэрээ байгуулах болон  
худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6, 8.7, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын гишүүн, барилга, хот байгуулалтын сайд болон Хэнтий аймгийн Засаг даргын хооронд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ”-ний 4.2 дахь заалтын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан IX.1.47 дугаартай “Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ (Хэнтий, Жаргалтхаан сум)”, IX.1.70 дугаартай “Цэвэр усны гадна шугам сүлжээ (Хэнтий, Өмнөдэлгэр сум)”, IX.1.77 дугаартай “Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)” төсөл арга хэмжээнүүдийн гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.

2.Төсөл арга хэмжээнүүдийн гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааны дүн, санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

2023 оны 02 дугаар сарын 02 ний  
 Д/г-аар захирамжийн хавсралт

(сая.төг)

№	Хуулийн дугаар	Төслийн нэр, хүчин чадал	Эхлэх он	Дуусах он	Анх батлагдсан төсөвт өртөг	2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн дүн	Үнийн өсөлтийн дүн	Нийт төсөвт өртөг	Батлагдсан төсвийн дагуу байгуулсан гэрээний дүн	Өмнө онуудад олгосон санхүүжилт	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах арга хэмжээ зохион байгуулах дүн	2023 онд санхүүжихээр батлагдсан дүн	2024 онд санхүүжих /үлдэгдэл/	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулах эсэх
1	ИХ.1.47	Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ (Хэнтий, Жаргалтхаан сум)	2020	2023	242.0	470.9	159.2	712.9	240.7	211.5	470.9	470.9	-	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах
2	ИХ.1.70	Цэвэр усны гадна шугам сүлжээ (Хэнтий, Өмнөдэлгэр сум)	2021	2023	1,482.0	567.9	159.2	2,209.1	1,450.8	1,450.8	567.9	567.9	-	ТБОНӨХБАУХА тухай хуулийн 40.6-р заалтын дагуу гэрээ байгуулах
3	ИХ.1.77	Гэр хороололын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)	2022	2024	29,950.0	-	-	51,279.62	29,806.7	5,400.0	-	18,266.36	6,140.29	Гэрээний дагуу үргэлжилж буй ажил
		Дүн			31,674.0	22,368.4	159.2	54,201.6	31,498.2	7,062.3	22,527.6	19,514.4	27,419.9	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах